



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар №33

Тавин

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 06 сарын 30-ны өдрийн 103 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тухай журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Ар-Урт, Өвөр-Урт, Сүм, Хашаат багуудад худгийн цооног шинээр барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга: Д.Нямсүрэн (Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: О.Ганбаатар (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Гишүүд: Г.Баасанжав (Хүний нөөцийн мэргэжилтэн)
Б.Мижиддорж (Сайнцагаан сумын Багийн Засаг дарга)

Х.Туяажаргал (Иргэний төлөөлөл)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Д.Нямсүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (О.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 1/12

Тавин

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах гүний худгийн цооног гаргах ДУГААСЗДТГ/2023/010 ажлын гүйцэтгэгчээр "Эрхэст Ундарга" ХХК-г сонгон гэрээ байгуулсугай.

2. Уг ажлыг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу гэрээний хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг "Эрхэст Ундарга" ХХК-ны захирал (М.Угтахбаяр)-т даалгасугай.

3. Гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ч.Оюунцэцэг), Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Уранцэцэг) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ

БАТЛАВ.

ДУНДГОВЬ АЙМГИЙН
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Ч.УРАНЧИМЭГ



БАТЛАВ.

“ЭРХЭСТ УНДАРГА” ХХК-НИЙ
ЗАХИРАЛ М.УГТАХБАЯР



**“БЭЛЧЭЭРИЙН УСАН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ГҮНИЙ ХУДГИЙН
ЦООНОГ “ГАРГАХ АЖЛЫН ГЭРЭЭ”**

Дугаар № ДУГААСЗДТГ/2023012

2023-07-05

Адаацаг сум

Нэг.Гэрээний нөхцөл

Нэг талаас /Адаацаг сумын ЗДТГазар/ (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас /**Сайхан овоо сум 1-р баг Онги Хадан хошуу “ ЭРХЭСТ УНДАРГА ” ХХК**/ (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 07 дугаар сарын 05 ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,Барилгын тухай хууль,бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй уст цэг шинээр байгуулах болон сэргээн засварлах ажил гүйцэтгэх ,тоног төхөөрөмж суурьлуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **“Бэлчээрийн усан хангамж сайжруулах гүний худгийн 4 цооног гаргах”**- /хөдөөгийн 4 багт тус бүх 1 цооног/ ажлын ДУГААСЗДТГ/2023012 (цаашид “ажил” гэх) 74 000 000 (Далан дөрвөн сая) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв.
3. Гэрээний үнэ санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно. Санхүүжилтийг ажлын гүйцэтгэл болон урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн эхний ээлжинд 40%, ажлаа комисст хүлээлгэн өгсний дараа 60% олгох ба ажлын 5 хоног дотор санхүүжилт хийнэ.Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх явцад гарсан зөрчил доголдолыг бүрэн арилгаагүй нь төлбөр хийхээс татгалзах үндэслэл болно.
4. Гэрээний нийт дүн:74 000 000 төгрөг. Үүнээс:
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө: 74 000 000 төгрөг
5. Гүйцэтгэгч нь **“Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах гүний худгийн 4 цооног гаргах”** ажлыг 2023 оны 07 дугаар сарын 05-ний өдөр эхэлж, 2023 оны 10 дугаар сарын 05 -ны өдөр ашиглалтад оруулна.

6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Бусад шаардлагатай баримт бичиг
 - Тендер;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Гэрээний ерөнхий нөхцөл;
 - Техникийн тодорхойлолт
 - Ажлын үе шатны ажлын хуваарь;
 - Ажлын зураг /Гүйцэтгэлийн зургаар/;
 - Санхүүжилтийн хуваарь;
 - Ажил гүйцэтгэх хуваарь
7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
8. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний бүх нөхцөл ,болзолд нийцүүлэн заасан ажлыг гүйцэтгэж,зөрчил гологдол гарсан даруйд арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг захиалагчаас нэхэмжлэх үүрэг хүлээнэ.
9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
10. Гүйцэтгэгч бараа материалын нэр ,тоо ширхэг нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувийг захиалагчид бүрдүүлж өгнө.
11. Чанарын баталгаа 2 жил байна.
12. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
13. Захиалагч болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран ажил гүйцэтгэх хугацаанд саатал гарсан тохиолдолд хамтран тохиролцож, ажлын графикт зохицуулалт хийсний үндсэн дээр ажил дуусгах хугацаанд өөрчлөлт оруулж болно.
14. Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж,захиалагчид учирсан аливаа хохирлыг нөхөн төлүүлнэ.
15. Гүйцэтгэгч нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5, 6.9-т заасны дагуу мэдээллийг оруулах үүрэг хариуцлагыг хүлээнэ.
16. Захиалагч нь гүйцэтгэгчийн төлөөлөлтэй ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах. Ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх.

Хоёр.Захиалагчийн эрх үүрэг

- 2.1.Захиалагч нь /Адаацаг сумын ЗДТГазар/ гүйцэтгэгчээс /Эрхэс ундрага ХХК/
Гэрээт ажлын явцад болон эцсийн гүйцэтгэлийн тайланг гаргуулан авах эрхтэй
- 2.2 Гэрээнд тусгасан ажлын явцад хяналт тавьж,гүйцэтгэлийг ажил хүлээн авах комиссын актаар баталгаажуулан хүлээн авч дүгнэнэ.
- 2.3 Захиалагч нь гүйцэтгэгчээс доорх материалуудыг бүрдүүлэн хүлээн авч гэрээг дүгнэнэ.
Инженерийн хийцтэй худгийн ажлын гүйцэтгэл
Ажил гүйцэтгэсэн тайлан,фото зургаар баталгаажуулсан байх
Ажил хүлээн авсан комиссын акт
Техникийн паспорт
Гэрээ дүгнэсэн маягтыг 2 хувь үйлдэнэ.
- 2.4 Захиалагч нь " Бэлчээрийн усан хангамж сайжруулах гүний худгийн 4 цооног гаргах"- "ажлын гүйцэтгэлийн техникийн тодорхойлолтонд заагдсан шаардлагыг хангаагүй бараа,ажлыг хүлээж авахаас татгалзах
- 2.5.Гүйцэтгэгч нь " Бэлчээрийн усан хангамж сайжруулах гүний худгийн цооног гаргах" ажлыг чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн зардлаар засуулах,нөхөн хийлгэх,санхүүжилтийг зогсоох учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах

Гурав.Гүйцэтгэгчийн үүрэг ,хариуцлага

- 3.1.Гэрээнд заагдсан ажлыг стандартын дагуу чанартай хийж гэрээнд заасан хугацаанд ашиглалтанд оруулан захиалагчид хүлээлгэн өгнө.
- 3.2.Ажил хийгдэж эхлэх болон явцын фото зургуудыг авч гүйцэтгэлийн тайланд хавсаргах
- 3.3.Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэхдээ техникийн аюулгүй ажиллагааг баримтлан заавар зөвлөгөө өгч ажиллах
- 3.4.Гүйцэтгэгч нь гэрээт хугацаанд ажлаа гүйцэтгэхийн тулд ажиллах хүч,техник,тоног төхөөрөмж,хүн хүчний нөөцөө чанарын өндөр түвшинд сайтар зохион байгуулах
- 3.5 "Бэлчээрийн усан хангамж сайжруулах гүний худгийн 4 цооног гаргах" ажлыг гэрээт хугацаандаа ашиглалтанд оруулаагүй бол нийт төсөвт өртгийн үнийн дүнгээс хоног тутам 0,5 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.Алданги төлснөөр ажил гүйцэтгэх үүргээс чөлөөлөгдөхгүй
- 3.6.Өрөмдмөл худаг ашиглалтанд орсноос хойш 1/нэг/ жилийн хугацаанд худагт ямар нэгэн гэмтэл,эвдрэл гарсан тохиодлолд хариуцлага хүлээж өөрийн компаний зардлаар хэвийн ажиллагаанд оруулж засах өгөх
- 3.7.Цооног хүлээн авахад техникийн паспорт бусад материалын хамт хүлээлгэн өгөх

Дөрөв. Маргаан шийдвэрлэх

4.1. Гэрээ нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлсэнээр дуусгавар болно.

4.2. Энэхүү гэрээний холбоотой талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

4.3. Хэрвээ санал зөрөлдөөнийг хэлэлцэн шийдвэрлэж чадахгүй бол хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.4. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА *Б.УРАНЦЭЦЭГ*

Утас: 99817252



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ЭРХЭСТ УНДАРГА" ХХК-НИЙ
ЗАХИРАЛ *М.УГТАХБАЯР*

РД: 3Л76072110

Данс: 5461162507 ХААНбанк/

Утас: 89202299





ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 772

Тавин

Төвийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих ажлыг хүлээн авах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Төвийн 2 худагт цэвэршүүлэх төхөөрөмж тавих” ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Оюунцэцэг (Засаг даргын орлогч)

Гишүүд: Ж.Батжаргал (1 дүгээр багийн Засаг дарга)

Ч.Урантуяа (Тамгын газрын Нярав)

Ө.Уранбилэг (Нягтлан бодогч)

Л.Бадамханд (Дунд сургуулийн Сургалтын менежер)

2. Дээрх ажлыг актаар хүлээн авч, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ

ЗАСАГ ДАРГА

БАТДАВ

Ч. УРАНЧИМЭГ

АДААЦАГ СУМЫН ОНХС-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2023 ОНД ХИЙГ ДЭХ БЭЛЧЭЭРИЙН УСАН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ГҮНИЙ ХУДГИЙН ЦООНОГ ГАРГАХ АЖИЛ"-ЫН АЖЛЫН ДААЛГАВАР.

2023-02-13.

Тавин.


1	Төсөл боловсруулах үндэслэл	Сумын ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 08 ны өдрийн хуралдааны 87 дүгээр тогтоолын хавсралтын 3,3,3,4 дахь заалт
2	Барилгын ажлын нэр /төрөл/ байршил	"Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах гүний 4 худгийн цооног гаргах ажил", Инженерийн өрөмдингийн ажил хийх газрын координатыг тодорхойлж зааж өгнө.
3	Ажлын хэмжээ зориулалт	Ар-Урт,Өвөр-Урт,Сүм,Хашаат-багт, 4 бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зориулалтаар 4 ш (дөрвөн) гүний худгийн цооног гаргана.
4	Төслийн захиалагч	Дундговь аймгийн Адаацаг сумын ЗДТГ
5	Ажиллах горим	Өдөрт 12 цагаас багагүй
6	Төслийн хүрээнд хийгдвэл зохих ажлын бүтэц	Гүйцэтгэгч ААН өөрийн зардлаар гидрогеологийн 6 хайгуул хийж өрөмдлөг хийх үст цэгийг тодорхойлно. Энэ тухай акт, холбогдох баримтыг хөтөлж, бүрдүүлнэ. Захиалагч хайгуул, өрөмдлөг хийх зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авна. Худгийн цооногийн хийц зохиомжийг MNS6088- 2010 стандартын шаардлагад нийцүүлэн 224 мм-ээс багагүй диаметртэйгээр өрөмдөж, суултын шүүрийн болон, ус дамжуулах янданг бүрэн, гүйцэт, нуралт үүсэхгүй байхаар тооцож төмөр хийцтэй Янданг сонгож суулгана. Өрөмдлөгийн ажлын Дараахь шахалтын ажлын үр дүнгээр худгийн усны ашиглалтын ундарга 1 л/с-ээс багагүй байна. Цооногийн суултын ус дамжуула хяндан нь хэрэглэгдэхэд зөвшөөрөгдсөн ган хоолой байна. Ус өргөх яндан 32 мм-ээс багагүй диаметртэй, хүйтний улиралд Зохицсон байна. Цооногийн хийц зохиомж нь түүнийг ашиглах бас эргээн засварлахад төвөгтэй биш байна. Цооногийн шавхалт, цэвэрлэлтийн хугацаа 8 цагаас багагүй байх бөгөөд ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ. Цахилгааны эх үүсгэвэрт холбох кабел утсыг шийдвэрлэж өгнө. Худгийн хувийн хэргийг хөтөлж, хүлээлгэж өгнө.
7	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага, аюулгүй байдал	Эрстэс уур амьсгалд /хүйтэнд/ ажиллахад тохиромжтой. Цахилгааны холболт зэрэг нь зохиулалтын хийцтэй байх.
8	Байгаль орчны үнэлгээ	Байгаль орчинд ээлтэй технологи хэрэглэх
9	Санхүүжилтийн эх үүсвэр, дүн	Сумын ОНХС Төсөв төртөг: 75,228,000 төг.
	Төсөл хэрэгжих үе шат, Хугацаа	Гүний худгийн цооног гаргах ажиллагаа 1 үе шаттай. Гэрээнд заасан хугацаагаа рбайна.
10	Захиалагчийн нэр, хаяг, утас	Дундговь аймгийн Адаацаг сум тавин баг. ЗДТГ- 11 ын байр. Утасны дугаар: 88822284, 88860996, 86096229.

ГЭРЭЭ ДҮГНЭХ МАЯГТ

2023 оны 10 сарын 05 ны өдөр

Гэрээний нэр	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах гүний худгийн цооног гаргах	
Гэрээний дугаар	ДУГААСЗДТГ/2023012	
Захиалагч байгууллага	Адаацаг сум Засаг даргын тамгын газар	
Гүйцэтгэгч байгууллага	"Эрхэст ундарга" ХХК	
Гэрээгээр ажил эхлүүлэх хугацаа	2023 оны 07 дугаар сарын 05-ний өдөр	
Гэрээгээр ажил дуусах хугацаа	2023 оны 10 дугаар сарын 05 -ны өдөр	
Гэрээний дүн	74,000,000 төгрөг	
Батлагдсан гүйцэтгэлийн дүн	Санхүүжилтийн дүн 74.000.000	
Гүйцэтгэгчээс ажил дууссан тухай мэдэгдэл ирүүлсэн өдөр	Гүйцэтгэгч Гэрээг 2023 оны 7 сарын 05 нд байгуулсан бөгөөд гэрээний хугацаандаа Хөдөөгийн 4 багт гүний худгийн цооног гаргасан бөгөөд 2023 оны 10 сарын 05 нд хүсэлтээ ирүүлсэн байна	
Комиссын актын дугаар	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах гүний худгийн цооног гаргах ажлыг 2023 оны 10 сарын 04 нгы өдрийн А/87 тоот Засаг даргын захирам жаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүлээн авлаа. Хүлээн авсан актын дугаар 5	
Гэрээний биелэлт , шийдвэрлэлт		
Гэрээний биелэлт	2-р багт эхнэхөв-Хүдгийн гүн 40м, 3-р баг Мануулт худгийн гүн-40м, 4-р баг Ёст худгийн гүн 82 м, 5-р баг Хишигтийн адаг худгийн гүн-100м өрөмдлөг хийж худаг гаргасныг хүлээн авлаа.	
Шийдвэр; Гэрээний үүргээ хугацаандаа биелүүсэн тул хүлээн авав. Төлбөрийг шилжүүлэхэд татгалзах зүйлгүй		

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Адаацаг сумын засаг даргын тамгын газрын дарга  Б.Уранцэцэг

Утас 99817252



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Эрхэст Ундарга" ххк-ний захирал
М.Угтахбаяр

Регистрийндугаар: 3437477
Данс: ХААН 5461162507

ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ЗӨВЛӨМЖ

2023.05.12

№ 01

Тавин

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн А/33 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо “Дундговь аймгийн Адаацаг сумын Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах гүний худгийн цооног гаргах ” ажлын ДУГААСЗДТГ/2023/010 дугаартай тендер шалгаруулалтыг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны хугацаанд 16 хоногийн хугацаатай tender.gov.mn хаягт цахимаар зарласан.

Тендер хүлээн авах хугацаанд “Эрхэст Ундарга” ХХК үнийн санал, бичиг баримт ирүүлсэн бөгөөд хянан үзэхэд техникийн санал шаардлагад нийцсэн, үнийн санал нь төсөвт өртөгт багтсан тул Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 22 өдрийн 01/100 албан тоотоор “Эрхэст Ундарга” ХХК-нд гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүргүүлсэн болно.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29.2-т заасны дагуу “Дундговь аймгийн Адаацаг сумын Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах гүний худгийн цооног гаргах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад хамгийн сайн үнэлэгдсэн “Эрхэст Ундарга” ХХК –тай 74000000 / Далан дөрвөн сая / төгрөгөөр гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



О.ГАНБААТАР